

**Говь-Алтай аймаг Цогт сум
“Натурал Ай Эн Эн” ХХК**

**“Ар ягаан чулуут” агнуурын бүс нутгийн
ан агнуурын менежментийн төлөвлөгөө**

Боловсруулсан: “Эко үйлчилгээ” агнуур зохион байгуулалтын мэргэжлийн
байгууллага

Танилцсан: Говь-Алтай аймгийн Цогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын дарга: Л.Насанбуян

Танилцсан: Говь-Алтай аймгийн Байгаль орчны газрын
дарга: О.Одгэрэл

Захиалагч: “Натурал Ай Эн Эн” ХХК

Гарчиг

Нэр томъёоны тайлбар, ойлголт	2-3
Өмнөх үг	4-6
1. ҮНДЭСЛЭЛ	6-7
1.1. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл.....	6-7
1.2. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах байгаль хамгааллын үндэслэл	7
2. АРГА ЗҮЙ	7-8
3. АГНУУРЫН БҮС НУТГИЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ОНЦЛОГ АГНУУРЫН АМЬТНЫ ҮНЭЛГЭЭ	9-15
3.1. Агнуурын бүс нутгийн хил хязгаар, экосистемийн онцлог	9-10
3.2. Мөст агнуурын бүс нутгийн янгир ямааны тоо толгой, тархац, амьдрах орчны үнэлгээ	10-15
4. АГНУУРЫН БҮС НУТГИЙН МЕНЕЖМЕНТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД	16
5. АГНУУРЫН БҮС НУТГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16-21
5.1. Зайлшгүй хамгаалах биологийн олон янз байдал, тэдгээрийн өнөөгийн байдал	16
5.2. Зорилго түүний шалгуур үзүүлэлт	17
5.3. Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдалд учирж буй аюул дарамтын үнэлгээ	17-19
5.4. Аюул дарамтыг бууруулах зорилт, үйл ажиллагаа	18-20
5.5. Санхүүжилтийн эх үүсвэр	20-21
Үйл ажиллагааны төлөвлөгөө /2015-2019 он/	22-28
Хавсралт 1. Мэдээлэл сурталчилгааны талаар	29-32
Хавсралт 2. Менежментийн төлөвлөгөөг боловсруулсан арга зүй	33-35

Хавсралт 2. Агнуурын бүс нутгийн зураглал

Нэр томъёоны тайлбар, ойлголт

"агнуурын амьтан" гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг;

"агнуурын нөөц" гэж хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо, хэмжээг;

“агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг;

“агнуурын амьтны сүргийн бүтэц” гэж сүрэг дэх амьтдын нас, хүйсийн харьцааг;

“ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг;

“амьтны нөөцийг хамгаалах” гэж амьтны сүргийн бүтцийн төлөв байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, байгалийн гамшиг, түймэр, халдварт өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, амьтны идэш тэжээлийн төлөө тэмцэл, хорогдлын шалтгааныг олж тодорхойлох, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх, тэдгээрт хяналт тавих цогц үйл ажиллагааг;

“ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг;

“олзворын ан” ан амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барих үйлийг;

“Һпорт ан” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд,
эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болголгүй агнах, барихыг;

“агнуурын зохион байгуулалт” гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл,
зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын
нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц
байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

“байгалийн нөөцийн хамтын менежмент” гэж нөхөрлөлийн хэлбэрээр зохион
байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан
хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд
нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион
байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг
байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ;

“агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч” гэж тухайн агнуурын бүс нутгийн
ай аай оодуй и ай аа ай ай деей д° ө° ае° а° °а оу дуй аа э э уу дуй ной ий Чаһаа аадһаа,
ае и аа, и дее нй уе деей аае аа әи и д- и и аһоо аае оад дее оһаи аае аоо өе ааа дае А и уо и и
додое доо ө и и 22.5-а чаһи и аад уо и дее уу ө ае и а и уа ае дее и оо аа оо аа дае аа аад,
оо аа өе а а дһаи ае дее и аа а да и а дае аа аад 30 д д д уе ае дее и оо аа оо аа дае а у д уу
аае аоо өһаи д д а у и, доо ө дее и у д а у у а дее а;

“зуучлагч байгууллага” гэдэгт спорт агнуур болон олз ай и д и и д а е у дее и а ай оод и а
ай д ааа оо д аа д, э д д д д а уу э э э э э уо э д а а д д аа аа аа у д д у е а у а доо ө дее и
у д а у у а дее а;

Өмнөх үг

Аливаа үйл ажиллагаа нь төлөвлөлттэй шууд холбоотой байдаг. Сайн төлөвлөлт нь хугацаа, санхүү, хөдөлмөрийг хэмнэж үл ойлголцлыг ч арилгаж тухайн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулдаг. Аливаа асуудлын учир шалтгааныг зөв олж тодорхойлох нь хамгийн хүнд үе шат юм. Хэрэв тухайн асуудал буюу бэрхшээлийн учир шалтгааныг буруу тогтоовол төлөвлөлт буруу болох юм уу, эсвэл төлөвлөлтөөс гарах үр дүн бага, хүсэн хүлээсэн үр дүн гарахгүй байх аюултай. Тиймээс хүсэн хүлээж буй үр дүндээ хүрэхийн тулд урт хугацаанд олон талаас нь хэлэлцэж сайн төлөвлөлтийг хийх нь зүйтэй.

Сүүлийн хэдхэн жилд байгалийн нөөцийн хомсдол хурдацтай нэмэгдэж байгааг бидэнд судалгааны олон тоо, баримт харуулж байгаа билээ. Экологийн процесс нь нэг нь нөгөөгөөсөө хамаарч байдаг аалзны тор шиг цогц үйл явц юм.

Энэхүү цогц үйл явцад хүний үйл ажиллагаа хамгийн багаар нөлөөлөх буюу байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хамгаалахын тулд нарийн цогц төлөвлөгөө шаардлагатай нь ойлгомжтой. Өнөөдөр хурдацтайгаар хомсдож байгаа биологийн олон янз байдлыг сэргээж, хамгаалахын тулд хөрөнгө мөнгө, хүн хүч, цаг хугацаа маш их шаардагдана. Гэтэл бидэнд тийм хангалттай хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө байхгүй байгаа учраас юуг, хаана, хэрхэн зохистой ашиглах вэ гэсэн хязгаарлал доор төлөвлөх нь илүү үр дүнтэй юм.

Дэлхий нийтэд хэрэгжүүлж байгаа байгалийн нөөцийн менежментийн төлөвлөлтийн олон арга зүй байдаг боловч доорх ерөнхий зарчим дээр тулгуурласан байдаг.

1. Бүх талуудын хамтын оролцоотойгоор төлөвлөх
2. Газар нутгийг сонгох
3. Учирч буй аюул, дарамт, түүний учир шалтгааныг тодорхойлсны үндсэн дээр стратеги төлөвлөгөөг боловсруулах
4. Хэрэгжүүлэх

5. Амжилтыг хэмжих

Тиймээс тодорхой газар нутагт байгаль хамгааллын төлөвлөлтийг боловсруулдаг арга зүйг тухайн газар нутгийн онцлог, туршлага дээр үндэслэн боловсруулах нь илүү ач холбогдолтой байдаг. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө гэдэг нь агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах буюу байгалийн нөөцийн хамтын менежментийн нэг хэлбэр юм. Энэхүү төлөвлөлт агнуурын амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгоход чиглэгдсэн болно. Өөрөөр хэлбэл амьтны экосистемд үзүүлэх үнэ цэнийг бууруулахгүй цаашид тогтвортой байлгах зорилгоор хамгаалах, зүй зохистойгоор ашиглах замыг эрэлхийлсэн нутгийн иргэд, байгаль хамгааллын нөхөрлөлийн оновчтой санаачлагууд нь эцэстээ энэхүү төлөвлөлтөнд тусгалаа олж хэрэгжих учиртай юм.

АНУ-ын TNC байгаль хамгааллын төрийн бус байгууллагын боловсруулсан CAP (Conservation action planning) буюу байгаль хамгааллын үйл ажиллагааны төлөвлөлт гэсэн арга зүйд тулгуурлаж Говь-Алтай аймгийн Цогт сумын “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутгийн байгаль хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан болно. Уг төлөвлөлтийг боловсруулахад орон нутаг болон нутгийн иргэд, байгаль хамгаалагч, олон талуудын оролцоог хамруулах, тэдний санал бодол дээр тулгуурсан гэдгийг онцолж дурдъя.

Байгалийн нөөцийн хамтын менежментийг хүрээнд Говь-Алтай аймгийн Цогт сумын “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутгийг тогтоон амьтны нөөцийн хамгаалал, зохистой ашиглалтын менежментийг орон нутгийн төрийн байгууллага, байгаль хамгааллын нөхөрлөл, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагааг удирдан зохицуулах зорилгоор энэхүү ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Мөст агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэх асуудал нь энэ нутгийн иргэдийн хүсэл эрмэлзэл бөгөөд нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг бий болгох эхлэл юм.

Энэ удаагийн ан агнуурын менежмент төлөвлөгөөний хамгийн гол ач холбогдол нь орон нутагт агнуурын зүйл амьтны хамгааллын өнөөгийн бодит байдлыг хөндөн гаргаж, цаашид нутгийн иргэд агнуурын амьтдыг хамгаалахад идэвхи санаачлагатай оролцох нөхцлийг бүрдүүлж байгаад оршиж байна. Энэхүү агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь ан амьтны

нөөцийг хамгаалах, тогтвортой өсөх нөхцлийг бүрдүүлснээр зохистой ашиглах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь цаг үеэ олсон, орон нутагт байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй бодлогын асуудлуудыг зөв, оновчтой шийдвэрлэж, төрийн болон нутгийн иргэд, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, нэгдсэн зорилго зорилтуудыг хамтын хүчээр үр дүнтэй шийдвэрлэх боломж нөхцлийг бүрдүүлсэн болно.

1. ҮНДЭСЛЭЛ

1.1. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн батлагдсан “Амьтны тухай хууль”-д хэд хэдэн шинэ үзэл баримтлалыг тусгасан. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 4.1.11 дэхь заалтад тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг нь **“ан агнуурын менежментийн төлөвлөгөө”** байна гэж тусгасан. Шинэчлэн батлагдсан “Амьтны тухай хууль”-ийн 5.3.2, 5.8.3, 21.4.1, 21.5.3, 22.3, 22.6, 23.1 дэхь заалтад ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулан, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу агнуурын бүс нутгийг тогтоон түүний тодорхой хэсгийг эзэмшүүлэх зэрэг үйл ажиллагааны зохицуулалт тусгагдсан.

Ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд суурилсан хамгаалал, зохистой ашиглалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2013 онд Засгийн газрын 07 дугаар тогтоолоор батлагдсан “Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох тухай журам”-ын 6.1-д хариуцаж буй агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байхаар тусгагджээ. Мөн түүнчлэн Засгийн 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ын 1.3-т тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч иргэн, хуулийн этгээд нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлнэ гэж тусгажээ.

Иймд “Амьтны тухай хууль”-ийн 21.4.1, 21.5.3 дэхь заалт, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ын 1.3, “Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох тухай журам”-ын 6.1 дэхь заалтыг тус тус үндэслэн Говь-Алтай аймгийн Цогт сумын Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн ан агнуурын менежмент төлөвлөгөөг нарийвчилсан агнуур зохион байгуулалт, нутгийн иргэдийн хэлэлцүүлэг, сумын байгаль орчны байцаагч, Засаг дарга нарын уулзалтын үр дүнд тулгуурлан боловсруулав.

1.2. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах байгаль хамгааллын үндэслэл

Аливаа үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт нь тухайн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөсөнтэй шууд холбоотой байдаг. Тийм ч учраас байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор боловсруулсан төлөвлөлт нь тухайн байгалийн нөөц, баялагт хүний үйл ажиллагаанаас одоо болон ирээдүйд гарч болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлох, түүний учир шалтгааныг олон арилгах, бууруулах зөв арга замыг хайх замаар боловсруулдаг. Хэрэв гарч байгаа сөрөг нөлөөний учир шалтгааныг буруу тогтоох, орхигдуулснаас зөв оновчтой үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Тиймээс хүсэн хүлээж буй үр дүндээ хүрэхийн тулд урт хугацаанд олон талаас нь хэлэлцэж сайн төлөвлөлтийг хийх нь зүйтэй.

Монгол улсын хөдөөгийн хүн амын амьжиргааны эх үүсвэр бэлчээрийн мал аж ахуй бөгөөд мал, зэрлэг амьтан, ургамлын бүлгэмдэл нь ус, бэлчээрийн төлөв байдлаас шууд хамааралтайгаар өсөн үрждэг билээ. Гэтэл сүүлийн 20-иод жилд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөө жишээлбэл цөлжилт, ган зуд, усны хомсдол, бэлчээрийн талхагдал нийт нутгийг хамрах боллоо. Энэ нь бэлчээрт суурилсан мал аж ахуй, түүнтэй зэрэгцэн оршин тогтонсоор ирсэн **зэрлэг амьтдын** хувьд эрсдэлд орох бодит аюул нүүрлэж байна. Үүнээс гарах олон арга замын нэг нь амьтны нөөц бүхий агнуурын бүс нутгийн байгалийн нөөцийн хамгаалал, зохистой ашиглалтын менежментийг нутгийн иргэдэд (байгаль хамгаалах нөхөрлөлд) хариуцуулах замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгох явдал юм.

2. Агнуурын бүс нутагт байгалийн нөөцийн хамгаалал, зохистой ашиглалтын менежментийг бий болгох ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан арга зүй

Говь-Алтай аймгийн Цогт сумын агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг Америкийн нэгдсэн улсын Де Нэйчэ Консерванси төрийн бус байгууллагын боловсруулсан САР буюу Байгаль хамгааллын үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх, давтагдах, сайжруулах үйл явцыг агуулсан процесс бүхий төлөвлөлт боловсруулдаг арга зүйг ашиглан боловсруулав. Учир нь агнуурын бүс нутгийн зөвхөн агнуурын амьтныг хамгаалах, зохистой ашиглах асуудал гэж хязгаарлаагүй харин тухайн агнуурын амьтан нь тухайн экосистемийн үйл явцын нэг бүрэлдэхүүн учраас агнуурын бүс нутгийн байгалийн нөөцийн менежмент гэсэн агуулгыг багтаасан болно.

Агнуурын бүс нутаг дахь биологийн олон янз байдалыг тогтвортой байлгахад зорилтот буюу зайлшгүй хамгаалах амьтан, ургамал, эко системийг сонгон зорилго дэвшүүлсэн. Мөн сонгосон амьтан, ургамал, экосистемд одоо болон ирээдүйд тулгарч буй аюул, дарамтыг олж тодорхойлох, түүн дээр түшиглэн зорилт боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дүгнэх/хэмжих энэ бүгдээс суралцаж дахин асуудлыг тодорхойлох, төлөвлөх гэх мэтээр үргэлжлэх тасралтгүй процесс гэж ойлгоно (Диаграмм-1).

Диаграмм 1. Байгаль хамгааллын үйл ажиллагаа



3. АГНУУРЫН БҮС НУТГИЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ОНЦЛОГ АГНУУРЫН АМЬТНЫ ҮНЭЛГЭЭ

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн танилцуулга

“Ар ягаан чулуут” агнуурын бүс нутаг нь амьтны аймгийн мужлалаар (Банников, 1953) Убөәдбәә асәеі әүә өд ібә, Мîíâîê-Г°âäеі ібә, Мîíâîêüí дүүдәеі аа îөд дүүдәеі әүә ібә, Баруун хойд Монголын тойрогт хамаарна.

Байгуулагдсан байдал


Говь-Алтай аймгийн Цогт сумын нутагт орших “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутаг нь аймгийн төвөөс 200 орчим км, сумын төвөөс 50 орчим км-т байрладаг. Тус аймгийн Цогт сумын удирдлагын санаачлага, “Натурал Ай Эн Эн” ХХК-ний санхүүжилт, захиалгаар байгаль орчны мэргэжлийн байгууллага “Эко үйлчилгээ” ТББ-г нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн болно.

3.1. Агнуурын бүс нутгийн хил хязгаар, экосистемийн онцлог

Газар зүйн байрлал, хил хязгаар, хэмжээ, газрын ангилал

Цогт сумын нутагт орших “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутаг нь Цахир хаалгын нуруу, Ар чулуут, Өвөр чулуут, Шар дэвсэг, Бугастын хөндий, Улаан бургастын гол, Гашууны худаг, Хөх даваа гэсэн нэр бүхий газруудыг хамарсан нийт 320.6 км² талбай нутгийг хамарна. Хавсралтаар хилийн цэсийг болон байршлын зургийг үзүүлэв.

Зураг 2. Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн байршил



**3.2. Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн янгир ямааны тоо толгой,
тархац, амьдрах орчны үнэлгээ**

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн агнуурын амьтад

Тус агнуурын бүс нутаг нь бадбóí òíèò ìííáíèúí òíèðíā òúúðèéí àìüðàä ìèííðíé áíèíâ÷ íéí àìüðàí íâíí èò áâñ áíâü ö°èèéíð ÷ íúâððúí íðæ èðäáúúðúú ìíðèíâ þ ì.


Тус агнуурын бүс нутаг орчимд агнуурын том хөхтний зүйлүүд цөөнгүй байдаг. Тухайлбал: янгир ямаа, аргаль хонь, саарал чоно, шилүүс, ирвэс, монгол тарвага, шар үнэг, хярс үнэг зэрэг болно.

Янгир ямаа


Ар ягаан чулуут агнуурын бүс нутагт янгир ямааны популяцийн онцлог нь тухайн агнуурын бүс нутаг нь бартаа саад ихтэйгээс гадна, хадан хавцал, нуранга асаг, эгц завчим хад чулуу элбэгтэй янгир ямаа байршин амьдрахад нэн тохиромжтой нутаг болно.

Тус агнуурын бүс нутагт тархсан янгир ямааны тархац нутгийг МСР буюу хамгийн бага гүдгэрт олон өнцөгтийн аргаар тогтооход 17,8%-д нь буюу 57,0 км² талбайд тархаж байгаа бол эзэмшил нутгийг Kernel аргаар 95, 75, 50%-ийн магадлалаар тооцоолон үзэхэд 194,6 км², 122,0 км², 53,4 км² нутагт тус тус тархаж байна.

Зураг 3. Янгир ямааны байршилг МСР буюу хамгийн бага гүдгэрт олон өнцөгтийн аргаар тооцоолсон байдал



Зураг 4. Агнуурын бүс нутагт тархсан янгир ямааны байршилг Kernel буюу эзэмшил нутгийг тооцоолсон байдал



Статус. Янгир ямаа (*Capra Sibirica, Pall 1775*) нь Монгол улсын Улаан номын хоёр удаагын хэвлэл (1987, 1997) ховор, 2001 оны Засгийн газрын тогтоолоор ховор, ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зэрэглэлээр тус тус хамгаалсанаас гадна тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон байдаг. Янгир ямаа нь Монголын хөхтний улаан дансанд олон улсын хэмжээн анхааралд өртөхөөргүй, бүс нутгийн хэмжээнд ховордож болзошгүй гэсэн ангилалд орсон байна.

Эрсдлийн хэлбэр: Бие гүйцсэн янгир ямааг махны зорилгоор ашигладаг уламжлалтай. Тэхийг эврийг авах зорилгоор гадаадын анчид агнадаг ч сүүлийн үед дотоодын зарим байгууллагууд (ресторан, кафе, жуулчны баазууд) ханын үзмэр болгох сонирхол бий.

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн янгир ямааны тоо толгой харьцангуй тогтвортой байршдаг байна.

Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын гол дүгнэлт:


Ар ягаан чулуут агнуурын бүс нутагт 270 км² дээж талбайд ажиглалт бүртгэл хийсэн нь АБН-ийн нийт талбайн 84,2% болж байна. Нийтдээ 8 сүргийн 68 бодгаль янгир ямаа тэмдэглэсэн байна.

Агнуурын бүс нутгийн янгир ямааны нөөцийг судалгаагаар тоологдсон бодгалийн тоо толгойд үндэслэн тооцоолон үзэхэд тус агнуурын бүс нутгийн хэмжээнд 81±4 янгир ямааны нөөцтэй байх боломжтой байна.

Сүргийн бүтэц сүрээглэл

Хээрийн хайгуулын явцад нийтдээ 8 сүргийн 68 бодгаль тэмдэглэв. Сүргийн бүтцийн харьцаанаас харахад 17 буюу 25,0% нь тэх, 36 буюу 52,9% нь эмгэж, 4 буюу 5,9% нь борлон, 11 буюу 16,2% нь ишиг байлаа.


График 1. Агнуурын бүс нутаг дахь янгир ямааны сүргийн бүтэц



Янгир ямааны сүргийн нөхөн үржихүйг хангагч биологийн хүчин зүйл болсон үржлийн тэх:эмгэжийн харьцаа 1:2.1 ногдож байгаа нь тус агнуурын бүс

нутгийн янгир ямааны сүргийн бүтцийн харьцаа хэвийн байгааг харуулж байна. Түүнчлэн сүргийн насны бүтцийг залуужуулах, жил бүр сүргийг нөхөн төлжүүлэх ёстой эмгэж:ишигний харьцаа 3.3:1 буюу 100 эхэд ногдох байдлаар 30.6%-тай байгаа нь популяцийн төллөлтийн үзүүлэлт бага байгааг илтгэж байна.

График 2. Эмгэж, ишигний харьцаа



Агнуурын нөөц, ашиглах боломжит хэмжээ


Нөхөн үржил

Тус агнуурын бүс нутгийн янгир ямааны сүргийн нөхөн төлжлийн үзүүлэлтийг тодорхойлогч эмгэж:борлонгийн харьцаа 9,0:1 буюу нөхөн төлжлийн үзүүлэлт нь 100 эхэд ногдох байдлаар 11,1%-тай байгаа нь тааруу үзүүлэлт болж байгаа бөгөөд агнуурын бүс нутгийн янгир ямааны сүргийн **нөхөн үржлийн чадавхи тааруу** байгааг харуулж байна. Агнуурын бүс нутгийн янгир ямааны нөөцийг судалгаагаар тоологдсон бодгалийн тоо толгойд үндэслэн тооцоолон үзэхэд “Аргалант” агнуурын бүс нутгийн хэмжээнд **81±4 янгир ямааны нөөцтэй** байх боломжтой байна.

Говь-Алтай аймгийн Цогт сумын нутагт орших “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутагт хийсэн судалгаагаар нийт ажиглагдсан янгир ямааны 25.0%-г тэх эзлэж байсан. Тус агнуурын бүс нутагт 7 сүрэгт хамаарах 17 тэх тэмдэглэгдсэнээс дээрх насны ангиллаар ялган үзвэл халиун тэх 6 буюу 35.3%, харлаг тэх 5 буюу 29.4%,

загал тэх 5 буюу 29.4%, их бага улаан тэх 1 буюу 5.9%-ийг тус тус эзлэж байна (График 3). Өөрөөр хэлбэл тус агнуурын бүс нутагт халиун тэх буюу агнуурын шаардлага хангасан 6 эр бодгаль байна.

График 4. Тус агнуурын бүс нутагт тэмдэглэгдсэн тэхийн насны ангилал



Агнуурын нөөцийн ашиглалтад “популяцийн нөхөн үржлийн чадавхи” гэдэг ойлголтоос гадна “агнуурын нөөцийн нөхөн үржлийн чадавхи”-ийг зайлшгүй харгалзах хэрэгтэй болдог. Популяцийн нөхөн үржлийн чадавхид борлонгын 100 эхэд оногдох харьцаа гол үзүүлэлт бодлог бол “тэхийн агнуурын нөөцийн нөхөн үржлийн чадавхи”-д доод насны тэхийн харьцаа гол үзүүлэлт болдог.

Тэхийн насны ангиллаас гадна насыг нь мөн тодорхойлох шаардлагатай байдаг. Судалгаагаар тэмдэглэсэн тэхэн дотор трофейн агнуурын шаардлага хангасан 6 тэх байна. Хойтон жил 5 тэх энэ насанд орж болохоор байгаагаас тухайн амьтдын нас хүйсний бүтцийг алдагдуулалгүйгээр агнуурын энэ нөөцийн 50 хувийг агнуулах боломжтой.

4. АГНУУРЫН БҮС НУТГИЙН МЕНЕЖМЕНТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх талууд

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх талууд:

1. Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн иргэд, идэвхтэн байгаль хамгаалагчид
2. Цогт сумын ЗДТГ, байгаль орчны байцаагч, газрын байцаагч, хөдөө аж ахуйн мэргэжилтэн гэх мэт
3. Сумын ИТХ тэргүүлэгчид
4. Говь-Алтай аймгийн Байгаль орчны газар
5. Байгаль орчны мэргэжлийн байгууллага
6. “Натурал Ай Эн Эн” ХХК

5. АГНУУРЫН БҮС НУТГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго нь агнуурын бүс нутагт агнуурын амьтанд учирч байгаа болон болзошгүй аюул дарамтыг арилгах, багасгах арга замыг тодорхойлох, нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялагийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах менежментийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгоход оршино.

Төлөвлөлтийн нэгдүгээр үе шат буюу тодорхойлох: *Тус газар нутгийн ямар экосистем, амьтан, ургамал, бүлгэмдлийг хамгаалснаар агнуурын бүс нутгийг бүхэлд нь цогцоор хамгаалж чадах вэ?*

Мөст агнуурын бүс нутгийн биологийн олон янз байдлыг төлөөлж чадахуйц амьтан, ургамлын зүйлийг зайлшгүй хамгаалах зорилготой биологийн олон янз байдлаар сонгов. Өөрөөр хэлбэл эдгээр сонгосон амьтан, ургамлыг хамгаалснаар энэхүү бүс нутаг бүхэлдээ хамгаалагдаж чадна гэсэн үг юм. Үүнд:

5.1. Зайлшгүй хамгаалах биологийн олон янз байдал, тэдгээрийн өнөөгийн байдал

Биологийн олон янз байдлын төлөөлөл болгож янгир ямаа, монгол тарвага гэсэн агнуурын амьтадад түшиглэж энэхүү төлөвлөгөөг боловсруулав.

5.2. Хоёрдугаар үе шат буюу менежмент төлөвлөгөөний зорилт түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах:

Биологийн олон янз байдлын төлөөлөл болгон сонгосон янгир ямаа, монгол тарваганы тоо толгойд одоо болон ирээдүйд учирч болзошгүй аюулын хэмжээг экологийн түлхүүр шинжинд нь тулгуурлан үнэлсэн. Аюул, дарамтыг тодорхойлохдоо дарамтын *зэрэглэл*, *цар хүрээ* гэсэн категориор маш их, их дунд, бага гэсэн үнэлгээг тохируулж өгсөн.

Зэрэглэл: Тухайн амьтны экологийн чадамжинд хэр их хүчтэй нөлөөлөх вэ гэдгийг харгалзан үзсэн.

Цар хүрээ: Тухайн аюул тухайн амьтанд нөлөөлж байгаа газар нутгийн хэмжээ хэр байх вэ гэдгийг харгалзан үнэлсэн.

5.3. Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдалд учирж буй аюул дарамтын үнэлгээ

Янгир ямаа, монгол тарваганы тоо толгой буурах аюул маш их, амьдрах орчин доройтох аюул их, гадаргын усны хомсдол их хэмжээгээр мөн аргаль хонинд амьдрах орчны хомсдол ихсэж байгаа аюул маш их хэмжээгээр нөлөөлж байна гэж үнэлэв. Янгир ямаа, монгол тарвага хоёрт учирах дарамтыг нэгтгэн үзсэн болно.

Хүснэгт 1. Янгир ямаа, монгол тарваганд учирж буй аюул, дарамт

Экологийн түлхүүр зүйл буюу чадамжинд учирж буй аюул		Янгир ямаа	Монгол тарвага
1	Популяцийн тоо толгой буурах	Дунд	Их
2	Амьдрах орчин доройтох	Их	Их
3	Гадаргын усны хомсдол	Бага	Бага
Аюулын нийлбэр дүн		Дунд	Дунд

Одоогоор эдгээр амьтадад гэрийн малаас халдварлах өвчлөлийн мэдээ баримт байхгүй учраас үнэлгээнд өвчлөлийг оруулаагүй болно.

Мөн аюулыг үүсгэж байгаа эх үүсвэрийг маш их, их, дунд, бага гэсэн үнэлгээгээр дүгнэв.

Янгир ямаа, монгол тарваганы популяцид учруулж буй дээрх 3 төрлийн илэрч буй аюул, дарамтыг хүний зүгээс бий болгож буй эх үүсвэрийг тодорхойлон нөлөөллийн зэргийг эрэмбэлж үзвэл:

1. Хууль бус агнуур дунд хэмжээгээр
2. Малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн доройтол их хэмжээгээр
3. Бэлчээрийн зохисгүй ашиглалт, бэлчээрийн ургамлын хэт ашиглалт их хэмжээгээр

4. Янгир ямаа, монгол тарваганы амьдрах орчин хомостох байдал их хэмжээгээр
5. Мэдээлэл дутмаг байгаа нь их хэмжээгээр
6. Хуулийн хэрэгжилт сул байгаа нь их хэмжээгээр
7. Агнуурын амьтдын ашиглалт, хамгаалалтад иргэдийн оролцоо сул байгаа нь их хэмжээгээр

Хүснэгт 2. Янгир ямаа, монгол тарваганд учирч буй аюул, дарамтыг бий болгож байгаа шалтгаан эх үүсвэрийн үнэлгээ

Янгир ямаа, монгол тарвага зэрэгт учирч буй аюулдарамтыг бий болгож байгаа эх үүсвэр		Янгир ямаа	Монгол тарвага	Үнэлгээний дүн
1	Хууль бус агнуур	Бага	Их	Дунд
2	Малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн талхагдал үүссэн	Их	Их	Их
3	Бэлчээрийн зохисгүй ашиглалт, бэлчээрийн ургамлын хэт ашиглалт (нүүдлийн хуваарийг мөрддөггүй)	Дунд	Дунд	Дунд
4	Янгир ямаа, монгол тарваганы амьдрах орчин хомостох байдал их хэмжээгээр	Дунд	Дунд	Дунд
5	Зэрлэг амьтны экологийн үнэ цэн, байгаль орчны мэдээлэл дутмаг	Их	Их	Их
6	Байгаль орчны хуулийн хэрэгжилт сул	Их	Их	Их
7	Агнуурын амьтдын ашиглалт, хамгаалалтад иргэдийн оролцоо хамтын ажиллагаа сул	Бага	Бага	Бага

5.4. Аюул дарамтыг бууруулах зорилт, үйл ажиллагаа

Говь-Алтай аймгийн Цогт сумын Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн янгир ямаа, монгол тарваганд учирч буй аюул, дарамтыг үүсгэж байгаа шалтгаан, эх үүсгэврийг бууруулахаар дараах зорилтуудыг дэвшүүлж байна (Хүснэгт-3). Үүнд:

Зорилт 1.	2018 он гэхэд янгир ямаа, монгол тарваганы хууль бус агнуурыг зогсоосон байна.
Шалгуур үзүүлэлт 1.1	Хууль бус агнуурын тандалт судалгаанд үндэслэсэн жилд

	илэрүүлсэн хууль бус агнуурын тоо хэмжээ
Шалгуур үзүүлэлт 1.2	Хууль бус агнуурын талаар иргэдээс ирүүлсэн мэдээлэл
Шалгуур үзүүлэлт 1.3	Янгир ямаа, монгол тарваганы тоо толгойн өсөлт
Шалгуур үзүүлэлт 1.4	Идэвхитэн байгаль хамгаалагчид монгол тарвага, янгир ямааны тоо толгой, амьдрах орчны өөрчлөлт, хэлбэлзлийг тодорхойлон анхан шатны мэдээллийг цуглуулдаг болсон байна
Зорилт 2.	2017 он гэхэд бэлчээрийг зохистой ашиглах журам, төлөвлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
Шалгуур үзүүлэлт 2.1	Бэлчээрийг талхагдлыг 30%-иар бууруулсан байна
Шалгуур үзүүлэлт 2.2	Бэлчээр сэлгэдгүй айлуудыг сэлгэдэг болгосон байна
Шалгуур үзүүлэлт 2.3	Малын тоог бэлчээрийн даацанд тохируулан одоогийнхоос нэмэгдэхгүй байна
Шалгуур үзүүлэлт 2.4	Нэгж малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлж малчин өрхийг орлогыг нэмэгдүүлсэн байна
Зорилт 3.	2017 он гэхэд менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгааллын зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн мэдээлэл харилцааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ
Шалгуур үзүүлэлт 3.1	2018 он гэхэд нутгийн иргэдийн 80% нь хамгаалж буй биологийн олон янз байдал (янгир ямаа, монгол тарваган)-ы талаар бүрэн мэдлэгтэй болж, 60% нь эерэг хандлага төлөвшиж, 40% нь хамгааллын арга хэмжээнд идэвхитэй оролцдог болсон байна
Шалгуур үзүүлэлт 3.2	2018 он гэхэд нутгийн иргэдийн 70% нь бэлчээрийн зохистой менежментийн талаар бүрэн ойлголттой болж, улмаар зөв зохистой ашиглалт 50%-д бий болсон байна
Зорилт 4.	2016 он гэхэд орон нутгийн удирдлагууд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай талуудын оролцоог бий болгож, санхүүжилтийг шийдсэн байна. Улмаар 2019 он гэхэд биелэлтийг бүрэн хангасан байна
Шалгуур үзүүлэлт 4.1	Нөхөрлөлийн удирдлага, зохион байгуулалт сайжирсан байна
Шалгуур үзүүлэлт 4.2	Тэхийн тусгай зориулалтын агнуураас олсон орлогын төлбөрийн 50% нь агнуурын менежментийг хэрэгжүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг болсон байна
Шалгуур үзүүлэлт 4.3	Гол, булаг, шандны усны нөөц одоогийнхоос буураагүй байна

Говь-Алтай аймгийн Цогт сумын Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийг сайжруулахаар дэвшүүлсэн дээрх 4 зорилтыг хэрэгжүүлж үр дүнг шалгуур үзүүлэлтэд хүргэхийн тулд жил бүр үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах болно. Жил бүрийн 07 сард үйл ажиллагааны хэрэгжилтийг хамтын оролцооны аргаар үнэлж дүгнэн дараа оны үйл ажиллагааг төлөвлөж байна. Мөн түүнчлэн менежмент

төлөвлөгөөний хэрэгжилийн үнэлгээнд тулгуурлан зорилт, үйл ажиллагааг шинэчлэн дахин боловсруулах төлөвлөлтийг сайжруулах болно.

5.5. Санхүүжилтийн эх үүсвэр

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд дараах 2 зорилгыг дэвшүүлсэн.

Зорилго 1. Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн янгир ямааны тоо толгойг 2018 он гэхэд одоогийн байгаагаас (2015 оныхоос) 20 хувиар өсгөнө.

Зорилго 2. Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн монгол тарваганы тоо толгойг 2018 он гэхэд одоогийн байгаагаас (2014 оныхоос) 20 хувиар өсгөнө.

Энэхүү дэвшүүлсэн 2 зорилгодоо хүрэхийн тулд янгир ямаа, монгол тарваганы тоо толгой, амьдрах орчинд учруулж буй аюул, дарамт тэдгээрийг үүсгэж буй шалтгаан эх үүсвэрийг бууруулах зорилгоор дэвшүүлсэн 4 зорилтын биелэлтийг хангахаар 2015 оны VII дугаар сараас 2019 оны VII сар хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсруулав.

Ар ягаан чулуут агнуурын бүс нутгаас 2016 онд 2 толгой тэхийг тусгай зөвшөөрлөөр агнуулна гэж тооцвол тэхийн агнуурын төлбөр 2000 ам доллар гэж үзэхэд үүний 50% нь Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журмын 6.6-д зааснаар болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2016 онд агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах боломжтой.

МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД МОНИТОРИНГ ХИЙХ

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, үнэлгээ: Агнуурын бүсийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх жил бүрийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг нөхөрлөлийн холбоо санаачлан бүх талуудтай хамтран боловсруулан ажиллана.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн талуудын үнэлгээнд үндэслэн менежментийн төлөвлөгөөний зорилтот үйл ажиллагаа, түүний чиглэлүүдэд нэмэлт өөрчлөлтийг талуудын оролцоотойгоор хэлэлцүүлэн шийдвэрлэж байна.

Төрийн хяналт, үнэлгээ: Аймгийн БО-ны газар болон суманд байгаль орчны талаарх хууль тогтоомжуудын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, санхүү, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг татварын байцаагч,

цагдаагийн тасаг ажилладаг бөгөөд үүрэг хариуцлагынхаа дагуу хяналт тавьж ажиллана.

Олон нийтийн хяналт, үнэлгээ: Энэхүү менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад Ар ягаан чулуут агнуурын бүс нутгийн иргэд, “Натурал Ай Эн Эн” ХХК, Байгаль орчны мэргэжлийн байгуулалгууд хяналт тавих эрхтэй.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2015-2019 ОН/

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа
--------	---------------	---------

Зорилго 1. Агнуурын зүйлүүдийг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцлийг бүрдүүлэх		
1.1. Агнуурын зүйлүүдийн мониторингийг өргөжүүлэн тогтмолжуулах, мониторинг хэрэгжүүлэгчид, оролцогчдыг чадавхижуулах	1.1.1. Агнуурын бүс нутгийн мониторинг судалгааны маршрутыг тогтоох	2015
	1.1.2. Биологийн төрөл зүйлийн судалгааг өргөжүүлэх	2015-2018
	1.1.3. Агнуурын зүйлийн зарим амьтдын зан төрх, нүүдэл, шилжилт, нөөцийн хөдлөл зүйг тандан судлах ажлыг эхлүүлэх	2016-2018
	1.1.4. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдыг мониторинг судалгааны мэдээлэл цуглуулах, бүртгэх арга зүйд сургах, чадавхижуулах	2015-2016
	1.1.5. Идэвхтэн байгаль хамгаалагчыг томилон ажлуулах	2015-2019
	1.1.6. Нутгийн иргэд хамтран агнуурын бүс нутаг дэвсгэр дээрээ байгалийн нөөцийг тогтоох зөвшөөрөгдсөн, хялбаршуулсан арга зүйг бий болгох	2015-2016
	1.1.7. Мониторинг судалгаанд шаардлагатай техник, багаж хэрэгсэлээр хангах, чанарыг нь сайжруулах	2015-2017
1.2. Агнуурын бүс нутгийг үнэлэх, бэлчээрийн менежментийн загваруудаас сонгон турших	1.2.1. Агнуурын бүс нутгийг нөхөрлөлүүдэд бүрэн хариуцуулан хамгаалах, хамгааллын ажлыг сайжруулах	2015-2016
	1.2.2. Нөхөрлөлүүдийн гишүүдэд өвөлжөө, хаваржааны орчмын бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлэх	2016
	1.2.3. Агнуурын бүс нутагт бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах	2016-2017
	1.2.4. Нөхөрлөлүүдийн гишүүдэд бэлчээрийн даац, нөөц, тогтвортой ашиглалтын менежментийн чиглэлээр сургалтууд зохион байгуулах	2016
	1.2.5. Тухайн бүсийн малчин иргэдийг оролцуулан бэлчээрийн менежментийн хэлэлцүүлэг зохион байгуулах	2016-2017
	1.2.6. Зэрлэг амьтдын бэлчээрийг шаардлагатай нөхцөлд чөлөөлөх	2016-2018

	1.2.7. Агнуурын бүс нутагт малын бэлчээрийн зохистой ашиглалтын хуваарь гарган мөрдүүлэх	2016
	1.3.1. Цогт сумын ИТХ-аар “Ар ягаан чулуут” агнуурын бүс нутаг болгон баталгаажуулах	2015
1.3. Агнуурын амьтдын байршилийг тогтворжуулах, нөхөн үржлийн хэвийн нөхцөлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	1.3.2. Агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежмент төлөвлөгөөг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх, талуудад хүргүүлэх	2015
	1.3.3. Агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу нөхөрлөлүүдэд эзэмшүүлэх	2016-2017
	1.3.4. Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авах газруудыг сонгон тодорхойлох, биотехникийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2016
	1.3.5. Янгир ямааны үржих, төллөх, үр төлөө өсгөх байршил нутгуудад хяналтыг эрчимжүүлэх	2016-2018
	1.3.6. Агнуурын зүйлүүдийн өвчлөл, паразитологийн судалгаа хийх	2017
	1.3.7. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжих үйл явц нь агнуурын зүйлүүдийн амьдрах орчныг өөрчилж буй эсэхэд мониторинг хийж тодорхойлох	2017-2018
	1.3.8. Ан амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх талаар газрын сонголт хийж нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах	2016-2017
	1.3.9. Агнуурын зүйлүүдийн популяцад хүний нөлөөг багасгах арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх	Жил бүр
	1.4. Мониторингийн судалгааны үр дүнг хамгаалалтын менежментэд хэрэглэх	1.4.1. Агнуурын зүйлүүдийн мониторинг судалгааг тогтмолжуулах төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
1.4.2. Ургамлын нөөц, бэлчээрийн даацын судалгааг тогтмолжуулах төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх		2017-2018
1.4.3. Агнуур зохион байгуулалтын судалгааг үндэслэн ангийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах төсөл хэрэгжүүлэх		2016-2019
1.4.4. Агнуурын зүйлүүдэд гэрийн малаас өвчин дамжихыг сааруулах зорилгоор байршлын давхцлыг багасгах		2016-2019

	1.4.5. Агнуурын бүсийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд танилцуулах сурталчилгааны материал хэвлэн түгээх зэрэг бусад арга хэмжээ зохион байгуулах	2016-2018
1.5. Мэдээллийн сан бүрдүүлэх	1.5.1. Тухайн бүсийн биологийн төрөл зүйлийн ажиглалтын судалгааг аймгийн БО Газар дээр төвлөрүүлэн биосан программд нэгтгэх	2016-2019
	1.5.2. Өмнөх хугацаанд хийгдсэн судалгаа, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн бүртгэх	Жил бүр
	1.5.3. Мэдээллийг байршуулан хадгалах, шаардлагатай тоног төхөөрөмж, программаар хангах, мэдээллийн цахим сангийн дизайн гаргах	2016-2017
	1.5.4. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдийн хариуцан хамгаалах нутаг дэвсгэрийн хил, байгалийн нөөцийн мэдээллийг зурагжуулах	2016-2017
Зорилго 2. Оролцоог хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох		
2.1 Удирдлага, зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох	2.1.1 Удирдлага зохион байгуулалтын бүтцийн саналыг (ажил үүргийн хуваарь, төсөв) боловсруулж удирдах зөвлөлийн /бүх гишүүдийн хурал/ хурлаар хэлэлцүүлэх	2015
	2.1.2. Шинэ бүтцээ холбогдох эрх бүхий газраар батлуулах	2015
2.2. Хамгаалалтын ажлыг удирдлагаар хангах, зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий талуудыг чадавхижуулах	2.2.1. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдтэй байгаль хамгааллын төлөвлөгөө гарган хамтын ажиллагааны урт хугацааны гэрээ байгуулан удирдлагаар ханган ажиллах	2015-2016
	2.2.2. Сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2016-2018
	2.2.3. Агнуурын бүс нутгийн менежментийг хэрэгжүүлэгч байгууллага, ажилтан, оролцогчдыг чадваржуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2016-2017
	2.2.4. Агнуурын нөөцийн хамтын менежментийн аргыг нэвтрүүлж буй туршлагаудтай танилцах (Бусад агнуурын бүсүүдийн)	2016-2017
	2.2.5. Бусад газар хэрэгжиж буй НИТАМ -ийн туршлага судлах	2017

2.3 Хяналт шалгалт, хамгаалалтын ажлыг сайжруулах	2.3.3. Хяналт шалгалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар батлуулж, хэрэгжүүлэх	2015-2019
	2.3.4. Хяналт, шалгалтын үр дүнг тогтмол мэдээлж байх	2015-2019
	2.3.5. Шаардлагатай газарт хяналтын камер суурилуулах	2015-2018
	2.4.1. Аймаг, сумын ЗДТГ-тай менежментийг хэрэгжүүлэхэд харилцан туслаж, хамтран ажиллах санамж бичиг гарган батлах	2015
	2.4.2. Төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулан ажиллах	2015
2.4 Хамтын ажиллагааг бүх шатанд өргөжүүлэх	2.4.3. Судалгаанд оролцогч нөхөрлөл, түүний идэвхтэн байгаль хамгаалагчид, аймгийн БО Газрын мэргэжилтэнтэй хамтын тогтвортой ажиллагааны гэрээ байгуулах	2015
	2.4.4. Янгир ямаа болон бусад зүйлүүдийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг тандан судлах	2016-2018
	2.4.5. Олон улсын болон гадаадын агнуурын байгууллага, анчидтай ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулан ажиллах	2015-2018
	2.4.6. Байгаль орчны ТББ-ууд, нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулж ажиллах	2015-2016
	2.4.7. Судалгаа, сургалт, агнуур зохион байгуулалтын байгууллагуудтай ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулж ажиллах	2015-2016
	2.4.8. Нөхөрлөлийн гишүүдээс байгаль орчны мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх	2016
Зорилго 3. Санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох		
3.1. Нөхөрлөлийн дундын санг байгуулах	3.1.1. “Дундын сан” байгуулах үндэслэл, санг бүрдүүлэх, захиран зарцуулах, сангийн үйл ажиллагааг хянан үнэлэх журмыг боловсруулан бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх	2016

	3.1.2. Санг байгуулах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах	2016
	3.1.3. Санд хуримтлал бүрдүүлэх, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тайлагнах	2016
3.2. “Агнуурын бүс нутгийн” хамгаалалтын үйл ажиллагааны зардлыг орлогоороо тогтвортой санхүүжүүлдэг байх	3.2.1. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн тооцоог тодотгон боловсруулах	2015
	3.2.2. Жил бүр байгалийн нөөц ашиглалтаас олсон орлогын зарцуулалтыг сайжруулах зорилгоор хамтран төлөвлөх уулзалтыг зохион байгуулах	2016
	3.2.3. Агнуурын ашгаас олсон нэмэлт орлогын зарцуулалтанд хяналт тавих, зарцуулалтын дүрмийг хамтран боловсруулах	2016
3.3. Тухайн бүс нутгийг түшиглэн өөрийн орлогыг олох бусад боломжуудыг туршиж үзэх	3.3.1. Өөрийн орлогын бусад эх үүсвэр, боломжуудыг туршиж үзэх /гар урлал, жижиг үйлдвэрлэл, аж ахуйн зарим хэлбэрүүд гм/	2016-2018
Зорилго. 4. НИТАМ-ийг хэрэгжүүлэн, агнуурын нөөцийг тогтвортой ашиглах		
4.1. Агнуурыг менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан эрхлэх	4.1.1. “Нарийвчилсан агнуур зохион байгуулалт”-ын тайланд дурдсан тоо хэмжээг аймаг, сумын төлөвлөлтөд тусгуулах	Жил бүр
	4.1.2. Хуульд заасан хугацаанд мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалт хийлгэх, нөөцийн үнэлгээг тогтоолгох	Жил бүр
	4.1.3. Агнуур зохион байгуулалтын судалгааг үндэслэн тусгай зөвшөөрлийн квот олгох саналыг орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад жил бүр уламжлан, шийдвэр гаргуулах	Жил бүр
	4.1.4. Агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллага (агнуурын аж ахуй, нэгж)-тай дунд хугацааны гэрээ байгуулах ажлыг эхлүүлэх	2016
	4.1.5. Агнуурын бүс нутгийн хилийн тэмдэгжүүлэлтийг хийх, өргөжүүлэх гэх мэт	2016

4.2. Агнуурын маркетингийг шинэ шатанд гаргах	4.2.1. Тусгай зөвшөөрлийн ангийн хуваарийг Төрийн захиргааны төв байгууллагаас урьдчилан авч агнуурын гэрээ хийх, бэлтгэл ажлыг хангах	2016
	4.2.2. Тусгай зориулалтын агнуурыг гадаадын анчдад зуучлагч ААН-үүдтэй хамтарсан уулзалт хийх	2016
	4.2.3. Гадаадын ангийн пүүсүүдийн судалгаа гаргах, тэдэнтэй тогтвортой хамтын ажиллагааны гэрээ байгуулах	2016
	4.2.4. Тусгай зөвшөөрлийн ан агнуур эрхэлдэг компаниудтай урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулах	2016
	4.2.5. Тухайн агнуурын өмнө болон дараа нь нөөцийн үнэлгээ хийлгэх, хяналт тавих	Жил бүр
	4.2.6. Маркетингийн мэдлэг олгох сургалтад нөхөрлөлийн гишүүдээс сонгон хамруулах	2016
	4.2.7. Төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын зуучлал, дэмжлэгээр төлөөлөгчөө ангийн бүтээгдэхүүн борлуулах үзэсгэлэнгүүдэд оролцож туршлага судлах	2016-2017
	4.2.8. Нөхөрлөлүүдийн ангийн отгийг шаардлага хангасан хэмжээнд зохион байгуулах.	Жил бүр
	4.2.10. Агнуурын нөөцийн хамтын менежментийн аргыг нэвтрүүлж буй туршлагуудтай танилцах	2016
	4.2.11. Агнуурын менежментийн үр ашгийг сурталчилах, тайлагнах	Жил бүр
	4.3. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг чадавхижуулах	4.3.1. Нөхөрлөлийн гишүүдийг агнуурын нөөцийн хамтын менежмент, тогтвортой ашиглалтын чиглэлээр сургах, чадваржуулах
4.3.2. Нөхөрлөлийн гишүүдийн орлогоо нэмэгдүүлэх, санал санаачлагуудыг дэмжих /шаардлагатай сургалтуудад хамруулах, бүтээгдэхүүнээ борлуулахад нь туслах г.м./		2016-2019
4.3.3. Бэлчээрийн судалгааны үр дүнд үндэслэн бүлэг, нөхөрлөлийн гишүүдэд бэлчээрийн даац, нөөц, тогтвортой менежментийн чиглэлээр сургалтууд зохион байгуулах		2016-2017

	4.3.1. Нөхөрлөлийн гишүүдэд ангийн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, агнуурын отгийн үйлчилгээ эрхлэх сургалт зохион байгуулах	2015-2016
	4.3.2. Нөхөрлөлүүдийн гишүүдэд нутаг дэвсгэр дээрээ байгалийн нөөцийн судалгааг хийх сургалт зохион байгуулах	2016
	4.3.3. Нөхөрлөлүүдийн туршлага, үйл ажиллагааг сурталчлах	2016-2017
4.4. НИТАМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн санал боловсруулах	4.4.1. Эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой саналуудыг уламжлан шийдвэрлүүлэх	2016
	4.4.2. Бизнесийн төлөвлөгөө боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэх	2016
	4.4.3. Агнуурын харилцааг зохицуулдаг хуулиудыг НИТАМ-ын зохицуулалттай уялдуулан сайжруулахад санал гаргах	2016
	4.4.4. Дотоод бүсийн дэглэмийг ан амьтдын шилжилт хөдөлгөөний онцлогтой уялдуулан уян хатан байх зарчмыг баримтлан бий болгох (боловсруулах)	2016
Зорилго 5. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол үнэлэх мониторингийн тогтолцоог бүрдүүлэх		
5.1. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үнэлэх тогтолцоог бүрдүүлэх	5.1.1. Сар бүр төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж байх, дүнг нөхөрлөлүүдийн зөвлөл, бусад оролцогч талуудад танилцуулан авах арга хэмжээг зохион байгуулах	Жил бүр

ХАВСРАЛТ -1. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

Мэдээлэл сурталчилгаа ба харилцааны талаарх ерөнхий ойлголтууд

1.1 Байгаль орчны мэдээлэл, харилцааны тухай ойлголт

Байгаль хамгаалалын ажлыг үр дүнтэй болгодог гол хэрэгсэл бол мэдээлэл, харилцаа юм. Иймээс ч байгаль орчны чиглэлийн аливаа менежментийн төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бол мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагаа байдаг. Байгаль орчны мэдээлэл, харилцааг дараах байдлаар ерөнхийлөн авч үздэг. Үүнд:

- ② Зорилтот бүлгүүдэд байгаль орчин, хүрээлэн буй орчны талаар тодорхой ойлголт өгч мэдлэг, хандлага, ухамсарыг нь төлөвшүүлэх, үйл ажиллагаанд татан оруулахад чухал үүрэгтэй хэрэгсэл;
- ② Байгаль орчны тогтвортой байдлыг хангах үр дүнтэй бодлого боловсруулах, олон нийтийн оролцоог бий болгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх туслах төлөвлөгөө, стратеги;

Үр дүнд хүргэхэд мэдээлэл, харилцаа холбоо хүчирхэг хэрэгсэл болдог учраас бид нэн тэргүүний асуудлуудаа тодорхойлж, тэдгээрт чиглэн гарч болох сөрөг нөлөөнөөс зайлсхийх үүднээс мэдээлэл, харилцаа холбооны ажлынхаа стратегийг тодорхойлж, төлөвлөх шаардлагатай.

1.2. Олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлын тухай ойлголт.

Олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажилд анхаарах гол хэд хэдэн асуудал байдаг. Үүнд:

- * Олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг ихэнхдээ тодорхой аяны хүрээнд явуулдаг. Жишээ нь: олон нийтийг хамарсан уулзалт, ярилцлага, асуудал хөндөх, олон нийт, шийдвэр гаргагчдад хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл хүргэх, олон нийтийн цугларалт, жагсаал, нийгмийн чанартай үйл ажиллагаа гэх мэт. Аливаа аян нь ард иргэдийн мэдлэг, ухамсар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэдэг учраас бид юуны өмнө эхлээд төлөвлөлтийг сайн хийх шаардлагатай.
- * Хүмүүс сонссон зүйлийнхээ 20 хувийг, сонссон ба харсан зүйлийнхээ 40 хувийг, харин сонсож хараад өөрсдөө хийсэн зүйлийнхээ 80 хувийг эргэн санадаг гэж үздэг тул аливаа мэдээллийг зөвхөн хүргээд зогсохгүй шууд хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал.
- * Дан ганц мэдээлэл өгсөнөөр зөв хандлага, дадал заншил төлөвшихгүй. Мэдээллийг сонсох, хүлээн авах, ойлгох, санал нийлэх, хэрэгжүүлэхэд хэд хэдэн саад байдаг учраас байнгын эргэх холбоотой байх нь чухал.

- ★ Олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг байх хэрэгтэй. Үнэлгээ нь тухайн ажлын үр дүн, ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг тогтооход чухал ач холбогдолтой. Үнэлгэг тоон ба чанарын үзүүлэлтээр гаргана. Тоон үзүүлэлт нь урт хугацааны чиг хандлага ямар байх, ямар ямар арга барил/хэрэглэснийг баримтаар гаргах болно. Чанарын үнэлгээ нь нарийвчилсан, нээлттэй явуулсан ярилцлага, хэлэлцүүлэг, ажиглалт болон холбогдох баримт бичгээс олсон мэдээ, мэдээлэлд үндэслэгддэг.

**Цогт сумдад хэрэгжүүлэх мэдээлэл харилцааны стратегийн чиглэлээр өгөх
ерөнхий удирдамж, бүтэц**

Стратеги 1. Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгааллын зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн мэдээлэл харилцааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

Мэдээлэл харилцааны зорилт 1

2018 он гэхэд нутгийн иргэдийн 80% нь хамгаалж буй биологийн олон янз байдал (янгир ямаа, монгол тарвага, задгай ус, булаг шанд)-ын талаар бүрэн мэдлэгтэй болж, 60% нь эерэг хандлага төлөвшиж, 40% нь хамгааллын арга хэмжээнд идэвхитэй оролцдог болсон байна.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад бидэнд суурь мэдээлэл дутмаг байсан тул мэдээлэл харилцааны зорилтуудыг ажиглалт дээр үндэслэн таамаглан боловсруулсан болно. Цогт суманд хэлэлцүүлэг хийж ард иргэдийн орон нутгийнхаа биологийн олон янз байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мэдээлэлээр хангах зэрэг өндөр зорилт тавих нь бодит үр дүнд хүрнэ гэж тооцоолж байна.

Мэдээлэл харилцааны зорилт 2

2018 он гэхэд нутгийн иргэдийн 70% нь бэлчээрийн зохистой менежментийн талаар бүрэн ойлголттой болж, улмаар зөв зохистой ашиглалт 30%-д бий болсон байна.

Стратеги 2. Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах талуудын оролцоог бий болгох

Мэдээлэл харилцааны зорилт 3

2015 он гэхэд орон нутгийн удирдлагууд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай талуудын оролцоог бий болгож, санхүүжилтийг шийдсэн байна. Улмаар 2019 он гэхэд биелэлтийг бүрэн хангасан байна.

Хэрэгжүүлэх арга зам

1. Холбогдох талуудын мэдлэг, хандлага, дадал заншлын суурь мэдээллийг бий болгох

Байгаль хамгааллын ч бай, мэдээлэл сурталчилгааны ч бай аливаа ажлын үр дүнг хэмжих шаардлагатай байдаг тул хамгийн түрүүнд суурь мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Тоон мэдээлэл бүхий буюу асуулга судалгаа, чанарын мэдээлэл бүхий фокус бүлгийн ярилцлагын арга зүйг хэрэглэнэ. Хэрвээ боломжтой бол жил бүр судалгааг явуулж үр дүнг тооцон, дахин төлөвлөлтийг хийх шаардлагатай.

2. Зорилтот бүлгийг тодорхойлох хүргэх мессежийг боловсруулах

Суурь мэдээллийн дүгнэлт дээр тургуурлан мэдээлэл харилцааны хөтөлбөрийг боловсруулна. Үүнд нэн тэргүүнд зорилтот бүлгээ тодорхойлж гаргах хэрэгтэй. Зорилтот бүлэгт бидний ухамсар, хандлагыг нь төлөвшүүлэхийг зорьж буй хүмүүс орно. Мөн асуудлыг албан ёсоор хариуцдаг хүмүүс, хүмүүсийн санал бодол, ухамсарт ажиллагаанд нөлөөлж чадах хүмүүс ч энд орно. Эдгээр зорилтот бүлэг бүрт хүргэх мэдээлэл, харилцаа холбооны арга өөр өөр байх шаардлагатай. Мэдээлэл, харилцаа холбооны гол зорилго нь эдгээр бүлгүүдийн хамтын ажиллагааг бий болгоход чиглэх болно. Юуны түрүүнд зорилтот бүлгийг сегментлэх буюу ангилах бөгөөд үүнд нутгийн нийт ард иргэд, нөхөрлөлийн гишүүд, бэлчээрийн менежментийн холбооны бүлгүүд, орон нутгийн удирдлага, хулгайн анчид, гаднаас ирж буй анчдад зуучлах магадлал бүхий иргэд зэрэг орно.

3. Зорилтот бүлэг тус бүрт хандсан мессежийг боловсруулах

Зорилтот бүлэг тус бүрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшил өөр өөр байдаг тул тохирох мессежийг гаргаж ирнэ. Тухайн мессеж энгийн ойлгомжтой, товч тодорхой, олон давталттай байх хэрэгтэй. Зорилтот бүлгийнхээ хэрэгцээнд үл нийцсэн ойлгомжгүй, хэт олон мэдээллийг нэг дор өгөхөөс зайлсхийх хэрэгтэй.

4. Арга хэрэгсэл буюу үйл ажиллагааг төлөвлөх

Мэдээлэл харилцааны маш олон арга хэрэгсэл байдаг бөгөөд хамгийн өргөн хэрэглэгддэг нь ном, гарын авлага, зурагт хуудас зэрэг хэвлэмэл материалбэлтгэх,

уулзалт цуглаан зохион байгуулж мэдээллийг түгээх, нэвтрүүлэг/кино хийж телевиз радиогоо цацах зэрэг ордог. Бүх арга хэрэгслийг зэрэг хэрэглэх нь хамгийн үр дүнтэй боловч санхүүгийн хувьд ихэвчлэн хүндрэлтэй байдаг тул сонголт хийх шаардлага тулгардаг. Харин эдгээрээс аль нь хамгийн үр дүнтэй нь чухам суурь судалгаагаар илэрдэг тул судалгааны үр дүнд тулгуурлах нь мөнгө санхүү, цаг хугацааг хэмнэх давуу талтай.

Байгаль хамгааллын төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагуудын судалгааны дүнг ажиглавал манайх шиг нүүдлийн соёл иргэншилтэй ард түмэнд хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол явуулын сургалт сурталчилгаа хийх явдал юм. Мөн багийн хурлын үеэр мэдээллийг түгээх нь ач холбогдолтой байдаг.

Ямар ч арга хэргэсэл сонгосон ч хүргэх мессежний нэгдмэл байдлыг хангах нь нэн чухал. Өөрөөр хэлбэл сонин дээр гарах нийтлэл, тараах номон дээр бичигдсэн зүйл, телевизээр ярьж байгаа хүн, багийн хурал дээрх мэдээллүүд бүгд НЭГ агуулгатай байх нь зорилтот бүлгийн итгэл үнэмшлийг төрүүлж улмаар оролцоог нэмэгдүүлдэг.

5. Цаг хугацаа, төсөв санхүү, талуудын оролцоог төлөвлөх

Нэгэнт арга хэрэгсэл/үйл ажиллагааг оролцооны аргаар тодорхойлон гаргасан тохиололд календарчилсан төлөвлөгөөг хийнэ. Үүнд тухайн үйл ажиллагааг хэн хариуцах, хэнтэй хамтрах, хэзээ хийх, ямар төсөв шаардагдах, санхүүгийн эх үүсвэр хаанаас гаргахыг төлөвлөнө.

ХАВСРАЛТ-2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН АРГА ЗҮЙ

Нэгдүгээр үе шат: Тодорхойлох: Энэ нь Хэн? Хаана? Юуг? хамгаалах гэдгийг тодорхойлно.

3.2. Тухайн газар нутгийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, бодлого боловсруулах, хуулийг хэрэгжүүлэх гэх мэт бүх талуудаас бүрдсэн



төлөвлөлтийг боловсруулах үндсэн нэгж буюу хамтран ажиллах талуудыг тодорхойлох;

3.3. Тухайн агнуурын бүс нутгийн хил хязгаарыг тодорхойлох;

3.4. Хил хязгаарыг тодорхойлсон агнуурын бүс нутгийн нутаг дэвсгэр дэхь биологийн олон янз байдлаас судалгаа, туршлагадаа тулгуурлан сонголт хийн юуг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах вэ гэдгийг тодорхойлох; Үүнд:

1. Амьтан, ургамлын зүйлүүд,

2. Бүлгэмдэл, 3.Экосистем зэрэг багтана. Эдгээр зайлшгүй хамгаалахаар сонгож авсан амьтан, ургамлын зүйл, бүлгэмдэл, экосистем нь төлөвлөлт хийж буй эко-бүс нутгийн биологийн олон янз байдлыг төлөөлж чадахуйц байх ёстой.

Хоёрдугаар үе шат: Байгаль хамгааллын зорилго, түүнийг хэмжих хэмжүүрийг боловсруулах:

2.1. Хамгаалахаар сонгож авсан биологийн олон янз байдлын экологийн чадамжид тулгуурлан байгаль хамгааллын зорилгыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл сонгож авсан биологийн олон янз байдлын экологийн түлхүүр шинж чанарт тулгуурлан үнэлгээ өгнө. Үнэлгээг өнгөрсөн, одоогийн байдал, ирээдүйд хүсэн хүлээж буй үр дүн гэсэн байдлаар өгнө. Энэ нь бидний сонгож авсан биологийн олон янз байдал байгаль дээр нөхөн сэргээгдэх чадвар ямар байгааг үнэлж өгдөг. Тухайлбал шинэсэн ойг бид зайлшгүй хамгаалах бүлгэмдэлээр сонгосон гэж үзвэл түүний экологийн гол түлхүүр процесс нь нөхөн ургалт байж болно. Өөрөөр хэлбэл нөхөн ургалт зогссон тохиолдолд тухайн бүлгэмдэл устах болно гэдгийг илтгэж байна. Сонгож авсан биологийн олон янз байдлыг нөхөн сэргээж хамгаалахын тулд тэрхүү экологийн түлхүүр шинж чанар дээр тулгуурлан төлөвлөгөөний зорилгыг боловсруулах болно.

Гуравдугаар үе шат: Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдалд учрах аюул, дарамт түүнийг бий болгож байгаа эх үүсвэр, шалтгааныг тодорхойлох;

Сонгож авсан биологийн олон янз байдалд ямар аюул одоогоор учирч байна, ямар дарамт ирээдүйд учирж болзошгүй вэ гэдгийг үнэлнэ. Аюулыг тодорхойлохдоо тухайн сонгосон биологийн олон янз байдлын экологийн түлхүүр шинж буюу чадамжинд тулгуурлах юм. Экологийн гол шинж чанар буюу чадамжинд нөлөөлж байгаа аюулыг тодорхойлохдоо *аюулын зэрэглэл, цар хүрээ* гэсэн шалгуураар үнэлгээ өгнө. Үүний дараа аюулыг үүсгэж байгаа эх үүсвэрийг мөн тодорхойлно. Аюулыг бий болгож байгаа учир шалтгаан эх үүсвэрийг тодорхойлохдоо тухайн аюулд оруулж байгаа *хувь хэмжээ, дарамтыг устгаж* чадах эсэх гэсэн шалгуураар үнэлгээ өгнө.

Дөрөвдүгээр үе шат: Зорилт, үйл ажиллагааг тодорхойлох; 4.1. Ямар үр дүнд хүрэхийг хүсэж байгаа зорилгодоо хүрэхийн тулд биологийн олон янз байдалд учирч байгаа аюулыг бууруулахад чиглэгдсэн зорилтыг хэмжиж болохуйц, тодорхой цаг хугацаатайгаар тодорхойлсон байна.

4.2. Тухайн зорилтонд хүрэх хамгийн шилдэг бөгөөд үр дүнтэй арга бүхий үйл ажиллагааг тодорхойлох;

Үйл ажиллагааг төлөвлөхдөө хэн, ямар хугацаанд, ямар санхүүжилтээр хэрэгжүүлэхийг хамтад нь төлөвлөж болдог. Нэг зорилтод хүрэхийн тулд нэг, түүнээс дээш үйл ажиллагааг төлөвлөнө. Жишээ:

Зорилт-1: 2018 он гэхэд хулгайн анг 2015 оныхтой харьцуулахад 2 дахин бууруулна.

Үйл ажиллагаа 1.1: Хулгайн ангын шалтгааныг тодорхойлох

Үйл ажиллагаа 1.2: Хулгайн антай тэмцэх баг байгуулах

Үйл ажиллагаа 1.3: Сургалт, сурталчилгаа хийх гэх мэт

*** Үр дүнг тодорхойлох илтгүүр/ индикаторыг тодорхойлох;** Тухайн зорилт сонгож авсан биологийн олон янз байдалд хэрхэннөлөөлснийг хэмжих нэгжийг тодорхойлно. Нэг зорилтод хэдэн ч индикатор байж болно. Индикатор нь хэмжигдэхүйц байх ёстой.

Тухайлбал: *Зорилт-1:* 2018 он гэхэд хулгайн анг 2015 оныхтой харьцуулахад 1 дахин бууруулна.

Индикатор: Хулгайн ангын тоо, хамрах хүрээ

Байгаль хамгааллын үйл ажиллагааны төлөвлөлтийн мэдээллийг тусгай программд оруулж үнэлгээг нэгтгэдэг.